




АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

АУДИТЫН НЭР: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



ОРОН НУТГИЙН БҮХ ШАТНЫ ИТХ-ААС ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ТАВИХ ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ САЙЖИРСАН БАЙНА.

Агуулга:

Тайлан бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	3
Архангай аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, аргазүй Аудитын тайлан	4-5 6-12
Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр	1 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСАНД НИЙТ БАЙГУУЛЛАГЫН 99.5 ХУВЬ НЬ ХАМРАГДСАН Ч ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭГДЭЭГҮЙ БАЙНА.	
Аудитын менежер Т.Байгалмаа	1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд 99.5 хувь хамрагдсан байна. 1.2.Татан буугдсан байгууллагууд болон холбогдох албан тушаалтны мэдээллийг шинэчлэх шаардлагатай байна.	
Аудитор Х.Алтанчимэг Г.Цог-эрдэнэ	2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН МЭДЭЭЛЭЛ 91.8 ХУВЬТАЙ МЭДЭЭЛЭГДСЭН БАЙНА.	
2017 оны 11 дүгээр сар	2.1 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээлэл 86.5 хувийн хэрэгжилтэй байна. 2.2 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээлэл 98.2 хувийн хэрэгжилттэй байна. 2.3 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт заасан мэдээллийг журмын дагуу мэдээлэхгүй байна.	
Уг тайланг Аудитын газрын Вэб сайт-аас үзнэ үү www.audit.mn	3. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ САЙЖИРСАН БАЙНА	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу	3.1.Хуулийн 8-р зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж байна. 3.2.Хуулийн 8-р зүйлийн 8.2-д заасан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. 3.3.Хуулийн 8-р зүйлийн 8.4-д заасны дагуу төсөв захирагчийн үр дүнгийн гэрээнд энэ хуулийн заалтыг тусган ажиллаж байна. 3.4.Хуулийн 9-р зүйлд заасан хяналт хэрэгжиж байна.	
Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	4.ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭЭС БОДИТ ҮР ДҮН БИЙ БОЛЖ БАЙНА.	
	4.1.Аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжсэн байна	
	4.2 Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж байна.	
	Дүгнэлт	13
	Тайлан баталгаажуулсан тушаал	14-15
	Зөвлөмж	16-17
	Холбогдох байгууллагын санал	18
	Хавсралт	19-27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮАГ	Үндэсний аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИНХ	Иргэд нийтийн хурал
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага

Аудитын нэр: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Аудитын код: УАГ-НАГ/2017/03-НА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ .

Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын хамрах хүрээ: Аудитад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд болон Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээдийн 2016 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ны өдрийг хүртэлх хугацааны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 стандарт болон, Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журам арга зүйг ашиглан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуй нэгжийн цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулган, дүн шинжилгээ хийх холбогдох албан тушаалтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулах зэрэг аргуудыг ашиглан аудитын хөтөлбөрийн дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж, боловсрууллаа

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа: Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

хууль;

- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудитыг Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Х.Алтанчимэг, Г.Цог-эрдэнэ, гэрээт ажилтан Ш.Лхамноржмаа, Х.Бадамцэцэг нар 2017 оны 10 дугаар сарын 20-оос 11 дүгээр сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл: Өмнөх Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 дэх заалтад хамаарагдах 184 байгууллага, аймаг, сумдын ОНХС-ийн мэдээллийг байршуулах 20 цэс шинээр нээгдэж нийт 204 байгууллага хамрагдсан нь нийт хамрагдвал зохих байгууллагын 94.4-ийг эзэлж байсан. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах нийт 204 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хуулийн 6.1, 6.4 дэх заалтын дагуу 2016 оны 3 дугаар улиралд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 1897 мэдээлэл тавихаас **88.4** хувь буюу 1676 мэдээллийг цахим хуудсанд байршуулж, **11.6** хувь буюу 221 мэдээллийг байршуулаагүй байсан. Аудитаар аймгийн Засаг даргад болон БСУГ-т зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага, ИТХ-д хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тус тус хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан байна.

БҮЛЭГ-1 ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСАНД НИЙТ ХАМРАГДВАЛ ЗОХИХ БАЙГУУЛЛАГЫН 99.5 ХУВЬ НЬ ХАМРАГДСАН Ч ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛИЙГ ШИНЭЧЛЭХ ХЭРЭГТЭЙ БАЙНА

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагуудын 99.5хувь нь хамрагдсан байна.

Шилэн дансны тухай хуулийг 2017 оны 3 дугаар улирлын байдлаар шалгахад нийт хамрагдвал зохих 207 байгууллагаас хуулийн 3.1.1¹ дэх заалтад хамаарагдах төрийн өмчит-23, орон нутгийн өмчит-157, ОНӨҮГ-1, хуулийн 3.1.2 ²дахь заалтад хамаарагдах ТӨҮГ-2, 3.2.2³ “Орон нутгийн хөгжлийн сан -20, 3.2.3⁴ “Засгийн газрын тусгай сан”-3 нийт 206 байгууллага буюу 99.5 нь хамрагдлаа. Харин шинээр байгуулагдсан Ойн анги шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгээгүй байна.

2. Татан буугдсан байгууллагууд болон холбогдох албан тушаалтны мэдээллийг шинэчлэх шаардлагатай байна.

Шилэн дансны 5 дугаар зүйлд зааснаар мэдээллийг ил тод нээлттэй бусдад ойлгогдохуйц байдлаар байршуулах ёстой ч зарим байгууллагууд тодруулга өгөх албан тушаалтны нэр хаягийг шинэчлээгүй, тодорхой бус мэдээлэл, хүснэгт зэргийг сайтад байршуулсан хэвээр байна. Мөн татан буугдсан Ихтамир, Эрдэнэмандал сумдын **Сум дундын ойн анги**, ажил гүйлгээ тайлан гаргадаггүй **Нийтлэг үйлчилгээний газар** зэрэг байгууллагуудын ашигладаггүй цэс сайтад байршсаар байна.

Цаашид цахим системийн мэдээллийн шинэчлэлтийг тухай бүр хийж хэвших шаардлагатай байна.

БҮЛЭГ-2 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН МЭДЭЭЛЭЛ 91.8 ХУВЬТАЙ МЭДЭЭЛЭГДСЭН БАЙНА.

2.1 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээлэл 86.9 хувийн хэрэгжилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарагдах нийт 206 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 2017 оны 3 дугаар улирлын байдлаар хуулийн 6.1 дэх заалтын дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ хэрхэн байршуулсныг хуулийн зүйл заалттай нийцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

¹ 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;

³ 3.2.2.орон нутгийн хөгжлийн сан

⁴ 3.2.3.Засгийн газрын тусгай сан;

1. Хуулийн 6.1.2⁵ “...сар улирлын гүйцэтгэл”-ийг 201 байгууллага давхардсан тоогоор нийт 2420 мэдээлэл тавихаас **92.6** хувь буюу 2243 мэдээллийг цахим хуудсанд мэдээлж, 177 мэдээллийг байршуулаагүй.
Тухайлбал: Булган сумын хүүхдийн цэцэрлэг, ахлах сургууль, Жаргалант сумын бага сургууль, ОНХСан, Цэнхэр сумын хүн эмнэлэг, Өлзийт сумдын төсөвт байгууллагууд.
2. Хуулийн 6.1.3⁶ “Дараа жилийн төсвийн төсөл”-ийг 179 байгууллага мэдээлэхээс **48.0** хувь буюу 86 байгууллага мэдээлж 93 байгууллага мэдээлээгүй.
Тухайлбал: Шүүхийн шинжилгээний алба, Стандарт хэмжилзүйн төв, Булган, Жаргалант, Ихтамир, Хангай, Цэнхэр сумдын төсөвт байгууллагууд.
3. Хуулийн 6.1.4⁷ “Хагас жилийн санхүүгийн тайлан”-г 200 байгууллага байршуулахаас **65.5** хувь буюу 131 байгууллага цахим хуудсанд байршуулж, 69 байгууллага байршуулаагүй.
Тухайлбал: Булган, Жаргалант, Өлзийт, Хотонт сумдын төсөвт байгууллагууд Эрдэнэбулган сумдын зарим хүүхдийн цэцэрлэгүүд.
4. Хуулийн 6.1.6⁸ “Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар”-ыг 200 байгууллага мэдээлэхээс **74.5** хувь буюу 149 байгууллага мэдээлж, 51 байгууллага мэдээлээгүй байна.
Тухайлбал: Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Аймгийн ТЕЗ, Булган, Цэнхэр сумдын төсөвт байгууллагууд.

2.2. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээлэл 98.2 хувийн хэрэгжилттэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар бүлэгт хамаарагдах нийт **206** төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ЗГ-ын тусгай сан, ОНӨҮГ, ТӨҮГ-ууд 2017 оны 3 дугаар улирлын байдлаар хуулийн 6.4 дэх заалтын дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ хэрхэн байршуулсныг хуулийн зүйл заалттай нийцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

- ❖ Хуулийн 6.4.1⁹ “тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт”-ийн талаарх мэдээллийг 67 байгууллага мэдээлэхээс **98.5** хувь буюу **66** байгууллага мэдээлж **1** байгууллага мэдээлээгүй байна.

⁵ 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор

⁶ 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор

⁷ 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

⁸ 6.1.6.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр

⁹ 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт

- ❖ Хуулийн 6.4.3¹⁰ “Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл” нийт 6 байгууллагад гарснаас 6 байгууллага 71 оролцогчийн мэдээллийг байршуулсан байна.

Гэхдээ Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүдийг өөрийн сайтдаа байршуулалгүй аймгийн ЗДТГ болон орон нутгийн өмчийн газрын цэсэнд байршуулж **мэдээлсэн** нь хэрэглэгчдийг төөрөгдүүлж байна.

- ❖ Хуулийн 6.4.4¹¹ “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл” нийт 56 байгууллага 4,027.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлсэн байна.
- ❖ Хуулийн 6.4.5¹² “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” 2016 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 45 байгууллага 36,431.3 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг, 10 байгууллага 33,913.0 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх орлого зардлын ихэнх хувийг нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих сангийн гүйлгээ эзлэж байна. Гэхдээ зарим төсөвт байгууллагууд дээрх хуулийн заалтын дагуу мэдээлэл тавихдаа цалин, НДШ-ийн зардлын мөнгөн гүйлгээг тус цэсэнд байршуулдаг, 5 саяас доош гүйлгээг мэдээлдэг байдал харагдаж байна.
- ❖ Хуулийн 6.4.6¹³. “Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн”-тэй холбоотой мэдээлэл 3 дугаар улирлын байдлаар гараагүй байна.
- ❖ Хуулийн 6.4.7¹⁴ дахь заалтын дагуу нийт 33 байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт орсноос 75.8 хувь буюу 25 байгууллага орон тооныхоо өөрчлөлтийг мэдээлж, 8 байгууллага мэдээллээ байршуулаагүй байна. Тухайлбал: Булган сумын төсөвт байгууллага, Цэцэрлэг сумын ЗДТГ.
- ❖ Хуулийн 6.4.8¹⁵ “..., төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах ... шийдвэр”-ийн талаарх мэдээллийг нийт 40 байгууллага 1907.0 сая төгрөгтэй холбоотой 1077 шийдвэрийг цахим хуудсанд мэдээлсэн байна.

Байгууллагууд төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэрээ байршуулахдаа шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартад

¹⁰ 6.4.3.тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

¹¹ 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

¹² 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

¹³ 6.4.6.худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн

¹⁴ 6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт

¹⁵ 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

заасан хавсралт маягтыг бүрэн бөглөдөггүйгээс төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрийг хянахад хүндрэлтэй нөхцөл үүсч байна. Мөн хамааралгүй тушаал шийдвэрийг байршуулах, PDF файлаар оруулдаггүй, сар бүрийн мэдээг гаргахдаа өглөг авлагын мэдээг гаргадаг ч цахим системд энэ талаарх мэдээллийг байршуулдаггүй зэрэг зөрчлүүд байсаар байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-6.1.6, 6.4-д заасан мэдээллүүдийг сайтад хэрхэн байршуулсаныг хавсралт дэлгэрэнгүй судалгаанаас байгууллага бүрээр харж болно.

Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг байршуулсан байдлыг нэгтгэн харуулбал:

Хүснэгт-1

Мэдээлвэл зохих хуулийн заалт	Мэдээлвэл зохих тоо	Үүнээс:			
		Мэдээлсэн		Мэдээлээгүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
6.1.2	2420	2243	92.6	177	7.3
6.1.3	179	86	48.0	93	52.0
6.1.4	200	131	65.5	69	34.5
6.1.6	200	149	74.5	51	25.5
дүн	2999	2609	86.9	390	13.0
6.4.1	67	66	98.5	1	1.5
6.4.3	95	95	100.0		0.0
6.4.4	322	318	98.8	4	1.2
6.4.5	583	583	100.0		0.0
6.4.7	33	25	75.8	8	24.2
6.4.8	1103	1077	97.6	26	2.4
дүн	2203	2164	98.5	39	1.8
НИЙТ ДҮН	5202	4773	91.8	429	8.2

Хүснэгтээс харахад Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг нийт байгууллагууд **91.8** хувьтай мэдээлсэн нь өмнөх оноос 4.1 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ч хуулинд заасан цаг хугацааг баримтлахгүй байна.

2.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 6 дугаар зүйлийн 6.5-д заасан мэдээллийг мэдээлсэн үү.

Шилэн дансны тухай хуулийн 6.5¹⁶-д заасан мэдээлэл орон нутагт хамааралгүй болно.

2.4 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8 дэх хэсэгт заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлж байна уу.

¹⁶ 6.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3¹⁷ дахь хэсэгт заасан байгууллагууд орон нутагт үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд хамааралгүй болно.

2.5 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт заасан мэдээллийг журмын дагуу мэдээлэхгүй байна.

2017 оны 09 сарын байдлаар аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим системд ОНХС-аар гүйцэтгэж буй төсөл арга хэмжээний **278.2** сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлсэн байна.

Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн төсөл арга хэмжээний **1041.2** сая төгрөгийн санхүүжилтын мэдээллийг байршуулаагүй байгаа бөгөөд энэ мэдээллийг хуулийн 6.9-д заасны дагуу авч үзвэл аймгийн ТЕЗ мэдээлэх ёстой боловч цахим сайтад тохирох цэс байхгүй байна. Нөгөө талаар журамд заасны дагуу хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ ажил үйлчилгээ **гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж** нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийг мэдээлэхгүй байна.

Цаашид аймгийн ТЕЗ-ийн цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж, хуулийн хугацааг мөрдөж ажиллаж шаардлагатай байна.

БҮЛЭГ-3 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ САЙЖИРСАН БАЙНА.

3.1 Хуулийн 8-р зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Хуулийн 8-р зүйлийн 8.1¹⁸-д зааснаар ТАБ өөрийн бүрэн эрхийн хүрээнд хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийт 5-н удаа хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэн, үр дүнтэй арга хэмжээ авч ирсэн байна.

Мөн заалтын дагуу бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2017 онд аймгийн ИТХ-аас “Сумдын ИТХ-ын ажлыг зөвлөн туслах, зөвлөмж чиглэл өгөх” удирдамж гарган 13 суманд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мөн “Либерал эмэгтэйчүүдийн сан” ТББ-тай хамтран шилэн дансны мэдээлэлд хяналт тавин ажилласан байна.

/Аймгийн ИТХ-ын 2017 оны 11 сарын 13-ны өдрийн 243 тоот албан бичиг/

3.2 Хуулийн 8-р зүйлийн 8.2-д заасан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

¹⁷ 3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

¹⁸ 8.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

Шилэн дансны хуулийн 8.2¹⁹ “ ... шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу ТЕЗ хэрэгжүүлнэ” гэж заасан бөгөөд үүний дагуу ТЕЗ-ийн дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудитын хамаарах хугацаанд 2 удаа хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтын дүнгээр шилэн дансны хуулийг 82.6 хувийн хэрэгжилттэй, хугацаа хоцрогдолтод анхаарч ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна. /Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2017.11.08-ны өдрийн 100 тоот албан бичиг/

3.3 Хуулийн 8-р зүйлийн 8.4-д заасны дагуу төсөв захирагчийн үр дүнгийн гэрээнд энэ хуулийн хэрэгжилтийг тусгаж ажиллаж байна.

Хуулийн 8.4²⁰-т заасны дагуу аймгийн ТЕЗ сумдын засаг даргатай гэрээ байгуулахдаа шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийн ил тод нээлтэй байдлыг тухай бүр мэдээлж ажиллах талаар тусгасан байдаг бөгөөд хагас бүтэн жилээр үр дүнг хэлэлцэн ажиллаж байна. Мөн СТСХ-ээс төсөв захирагч нарт шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж аргагүйн зөвлөгөө өгч, мэдээллээ бүрэн байршуулаагүй тохиолдолд хариуцлага тооцож ажиллах талаар албан бичгээр мэдэгдэж ажиллаж байна. /СТСХ-ийн 2017 оны 11 сарын 13-ны 08/1284 тоот албан бичиг/

3.4 Хуулийн 9-р зүйлд заасан хяналт хэрэгжиж байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдол ирээгүй байна. Харин 2017 оны тухайд аймгийн захиргааны хэргийн шүүхэд хуулийн 9.3²¹ -дахь заалтын хүрээнд 1 санал, гомдол ирснийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. /Шүүхийн тамгын газрын 2017 оны 11 сарын 09-ны өдрийн 281 тоот албан бичиг/

БҮЛЭГ-4 ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭЭС БОДИТ ҮР ДҮН БИЙ БОЛЖ БАЙНА.

4.1 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

2016 оны 3 улиралд хийсэн шилэн дансны аудитаар аймгийн ТЕЗ болон БСУГ шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллалаа.

4.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

¹⁹ 8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ

²⁰ 8.4.Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.

²¹ 9.3.Иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Өмнөх аудитаар аймгийн ИТХ-д хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж бүх шатны ИТХ-д үүрэг өгч тодорхой үр дүнтэй арга хэмжээ авах зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллалаа. Аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу аймгийн ИТХ 13 суманд зөвлөн туслах үйл ажиллагаа явуулж, хяналт тавьж ажилласан бөгөөд бусад сумдад мөн ажиллахаар төлөвлөсөн байгаа нь аудитын зөвлөмжийн дүнд хуулийн хэрэгжилт хангагдаж, сахилга хариуцлага сайжрах үр дүнг бий болохоор байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ❖ ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСАНД НИЙТ БАЙГУУЛЛАГЫН 99.5 ХУВЬ НЬ ХАМРАГДСАН Ч ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ШИНЭЧЛЭГДЭЭГҮЙ БАЙНА.
- ❖ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН МЭДЭЭЛЭЛ 91.8 ХУВЬТАЙ МЭДЭЭЛЭГДСЭН БАЙНА.
- ❖ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ САЙЖИРСАН БАЙНА
- ❖ ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭЭС БОДИТ ҮР ДҮН БИЙ БОЛЖ БАЙНА.

АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2017.11.17

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 1128

Цэцэрлэг

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 тушаалын 5 дугаар хавсралтын 1.2 дахь заалт, 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дахь заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2017 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг УАГ-ын нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг нийцлийн аудитын багийн аудитор /Х.Алтанчимэг/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР



Тэргүүлэх аудиторын 2017 оны // сарын 18 өдрийн 48 тоот тушаалын хавсралт

Аудитаар илрүүлсэн зөрчлийн нэгтгэл

№	Хариуцагч			Утга	Албан шаардлага, зөвлөмж	Үүнээс		Үр өгөөж тооцох эсэх	
	Овог, нэр	Албан тушаал	Сум байгууллага			Зөрчил арилгах	Зөвлөмж	Санхүүгийн	Санхүүгийн бус
1	Ц.Мөнхнасан	Засаг дарга	Аймаг	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, хуулийн хугацаанд мэдээллийг байршуулж	Зөвлөмж		1		1
2	Ч.Насанжаргал	Засаг дарга	Булган сум		АШ	1			1
НИЙТ						1	1		2

Нэгтгэл гаргасан: Аудитор

[Signature]

Х.Алтанчимэг

